

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Зүүнбаянгийн хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/24/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Дорноговь аймаг	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
2026 он	Ахлах аудитор/Аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com Аудитор Ц.Ганцэцэг Утас: 8905-6740 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: domogovi@audit.gov.mn

2026.02.25 № 1-6/135

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「САЙНШАНД СУМЫН ЗҮҮНБАЯН  
БАГИЙН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Б.БУДСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Зүүнбаян багийн хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Сайншанд сумын Зүүнбаян багийн цэцэрлэгийн их засварын ажил”-ыг “Эргэл хийц” ХХК 692,920.2 мянган төгрөгөөр гүйцэтгэснийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2025 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт, хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

442505123

Шилэн дансны тухай хуульд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, тогтмол мэдээлэх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн боловсролын газрын даргаар батлуулж, хэрэгжилт 88.5 хувьтай үнэлэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>126,939,451.84</b>	<b>92,353,007.71</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	73,238,143.48	19,290,428.35
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	73,238,143.48	19,290,428.35
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	73,238,143.48	19,290,428.35
31211	Төрийн сангийн харилцах	73,238,143.48	19,290,428.35
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,302,314.00	1,631,814.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,302,314.00	1,631,814.00
3351	Байгууллагаас авах авлага	1,302,314.00	1,631,814.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	52,398,994.36	71,502,765.36
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,578,100.00	4,578,100.00
35110	Тусгай зориулалттай материал	4,578,100.00	4,578,100.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	47,820,894.36	66,852,665.36
35410	Бичиг хэргийн материал	423,500.00	471,500.00
35420	Аж ахуйн материал	37,594,049.29	44,449,909.29
35440	Түлш, шатах тослох материал	0.07	0.07
35450	Барилгын засварын материал	869,200.00	869,200.00
35460	Хүнсний материал	1,367,845.00	3,410,556.00
35470	Бусад хангамжийн материал	7,566,300.00	17,651,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>524,282,538.89</b>	<b>1,214,703,542.38</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	524,282,538.89	1,214,703,542.38
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	471,698,538.89	1,162,119,542.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	592,502,235.00	1,285,422,412.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(132,324,266.15)	(158,334,089.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,554,960.00	71,981,360.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,814,532.81)	(39,888,053.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,150,378.25	79,150,378.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(75,438,235.40)	(76,280,465.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,815,000.00	13,815,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,800,000.00)	(13,800,000.00)
39217	Ном	53,000.00	53,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	52,584,000.00	52,584,000.00
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,727,000.00)	(1,727,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	52,584,000.00	52,584,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>651,221,990.73</b>	<b>1,307,056,550.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,450,400.00</b>	<b>2,779,900.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,450,400.00	2,779,900.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,450,400.00	2,779,900.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,260,000.00	2,260,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	190,400.00	519,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	87,400.00	87,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	103,000.00	432,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>648,771,590.73</b>	<b>1,304,276,650.09</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	648,771,590.73	1,304,276,650.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	480,946,136.05	480,946,136.05
51101	Өмч: - төрийн	480,946,136.05	480,946,136.05
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	167,825,454.68	823,330,514.04
51210	Өмнөх үеийн үр дүн	167,825,454.68	167,825,454.68
51220	Тайлант үеийн үр дүн	-	655,505,059.36
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>651,221,990.73</b>	<b>1,307,056,550.09</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>882,261,609.89</b>	<b>1,674,452,030.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,000,000.00</b>	<b>736,663,437.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,000,000.00	736,663,437.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	12,743,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	12,743,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан -Үндсэн хөрөнгө		722,346,577.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан -Бараа материал		1,573,360.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>881,261,609.89</b>	<b>937,788,593.55</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	829,779,700.00	884,225,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	829,779,700.00	884,225,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	51,481,909.89	53,563,093.55
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,481,909.89	53,563,093.55
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>906,436,733.65</b>	<b>1,018,946,971.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>906,436,733.65</b>	<b>1,018,946,971.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	906,436,733.65	1,018,946,971.19
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	685,371,566.26	777,115,700.08
210101	Үндсэн цалин	436,062,272.50	488,639,235.63
210102	Нэмэгдэл	227,059,673.76	239,681,217.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	22,182,947.08
210104	Урамшуулал	22,249,620.00	26,612,300.08
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,725,116.90	94,692,810.05
210201	Тэтгэврийн даатгал	51,374,087.03	63,608,310.05
210202	Тэтгэмжийн даатгал	6,705,699.40	7,771,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,327,876.49	3,885,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,235,799.57	3,885,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,081,654.41	15,542,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48,923,009.89	50,563,093.55
210301	Гэрэл, цахилгаан	10,648,366.89	11,522,190.55
210302	Түлш, халаалт	32,483,100.00	32,483,143.00
210303	Цэвэр, бохир ус	5,791,543.00	6,557,760.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,913,450.00	9,996,534.00
210401	Бичиг хэрэг	736,400.00	4,387,534.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,177,050.00	3,689,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,920,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	45,140,055.00	46,900,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	68,500.00
210502	Хоол, хүнс	45,140,055.00	46,832,260.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,580,260.00	-
210604	Урсгал засвар	4,580,260.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	785,000.00	2,803,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	785,000.00	2,803,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,998,275.60	36,874,473.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,818,900.00	4,948,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,883,400.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,295,975.60	31,925,573.51
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(24,175,123.76)</b>	<b>655,505,059.36</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(608,458.96)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(24,783,582.72)</b>	<b>655,505,059.36</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>882,261,609.89</b>	<b>950,532,093.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,000,000.00</b>	<b>12,743,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,000,000.00	12,743,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	12,743,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	12,743,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>881,261,609.89</b>	<b>937,788,593.55</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	829,779,700.00	884,225,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	829,779,700.00	884,225,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	51,481,909.89	53,563,093.55
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,481,909.89	53,563,093.55
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>870,223,738.05</b>	<b>1,004,479,808.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>870,223,738.05</b>	<b>1,004,479,808.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>870,223,738.05</b>	<b>1,004,479,808.68</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	685,371,566.26	777,115,700.08
210101	Үндсэн цалин	436,062,272.50	488,639,235.63
210102	Нэмэгдэл	227,059,673.76	239,681,217.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	22,182,947.08
210104	Урамшуулал	22,249,620.00	26,612,300.08
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,725,116.90	94,692,810.05
210201	Тэтгэврийн даатгал	51,374,087.03	63,608,310.05
210202	Тэтгэмжийн даатгал	6,705,699.40	7,771,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,327,876.49	3,885,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,235,799.57	3,885,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,081,654.41	15,542,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48,923,009.89	50,563,093.55
210301	Гэрэл, цахилгаан	10,648,366.89	11,522,190.55
210302	Түлш, халаалт	32,483,100.00	32,483,143.00
210303	Цэвэр, бохир ус	5,791,543.00	6,557,760.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	40,447,995.00	49,188,171.00
210502	Хоол, хүнс	40,447,995.00	49,188,171.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,558,900.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,558,900.00	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	779,200.00	2,928,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	779,200.00	2,928,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,917,950.00	26,991,434.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,413,850.00	22,862,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,504,100.00	4,129,034.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,537,871.84</b>	<b>(53,947,715.13)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,951,810.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,951,810.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,951,810.00	-
222001	Тоног төхөөрөмж	1,951,810.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,951,810.00)</b>	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	9,586,061.84	(53,947,715.13)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		73,238,143.48
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	73,238,143.48	19,290,428.35

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	480,946,136.05	192,609,037.40	673,555,173.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>480,946,136.05</b>	<b>192,609,037.40</b>	673,555,173.45
Тайлант үеийн үр дүн	-	(24,783,582.72)	(24,783,582.72)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>480,946,136.05</b>	<b>167,825,454.68</b>	648,771,590.73
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>480,946,136.05</b>	<b>167,825,454.68</b>	648,771,590.73
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>480,946,136.05</b>	<b>167,825,454.68</b>	648,771,590.73
Тайлант үеийн үр дүн	-	655,505,059.36	655,505,059.36
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>480,946,136.05</b>	<b>823,330,514.04</b>	1,304,276,650.09

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,036,870,400.00</b>	<b>1,004,479,808.68</b>	<b>(32,390,591.3)</b>	<b>96.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,036,870,400.00</b>	<b>1,004,479,808.68</b>	<b>(32,390,591.3)</b>	<b>96.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,036,870,400.00</b>	<b>1,004,479,808.68</b>	<b>(32,390,591.3)</b>	<b>96.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>777,115,600.00</b>	<b>777,115,700.08</b>	<b>100.1</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	513,094,700.00	488,639,235.63	(24,455,464.4)	95.2
210102	Нэмэгдэл	237,408,500.00	239,681,217.29	2,272,717.3	101.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	22,182,947.08		
210104	Урамшуулал	26,612,400.00	26,612,300.08	(99.9)	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>96,649,000.00</b>	<b>94,692,810.05</b>	<b>(1,956,190.0)</b>	<b>98.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	65,564,500.00	63,608,310.05	(1,956,190.0)	97.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,771,200.00	7,771,200.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,885,500.00	3,885,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,885,500.00	3,885,500.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	15,542,300.00	15,542,300.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>55,951,500.00</b>	<b>50,563,093.55</b>	<b>(5,388,406.5)</b>	<b>90.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,264,000.00	11,522,190.55	(3,741,809.5)	75.5
210302	Түлш, халаалт	32,483,100.00	32,483,143.00	43.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	8,204,400.00	6,557,760.00	(1,646,640.0)	79.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>69,081,300.00</b>	<b>48,858,671.00</b>	<b>(20,222,629.0)</b>	<b>70.7</b>
210502	Хоол, хүнс	69,081,300.00	48,858,671.00	(20,222,629.0)	70.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,928,600.00</b>	<b>3,305,200.00</b>	<b>376,600.0</b>	<b>112.9</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,928,600.00	3,305,200.00	376,600.0	112.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,144,400.00</b>	<b>26,944,334.00</b>	<b>(5,200,066.0)</b>	<b>83.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,734,100.00	23,191,900.00	(3,542,200.0)	86.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,410,300.00	3,752,434.00	(1,657,866.0)	69.4
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>966,610,400.00</b>	<b>950,532,093.55</b>	<b>(16,078,306.5)</b>	<b>98.3</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>908,659,200.00</b>	<b>884,225,500.00</b>	<b>(24,433,700.0)</b>	<b>97.3</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	908,659,200.00	884,225,500.00	(24,433,700.0)	97.3
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>57,951,200.00</b>	<b>53,563,093.55</b>	<b>(4,388,106.5)</b>	<b>92.4</b>
132001	Орон нутгийн төсвөөс	57,951,200.00	53,563,093.55	(4,388,106.5)	92.4
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		<b>-</b>	<b>12,743,500.00</b>	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	12,743,500.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>73,238,143.48</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>19,290,428.35</b>		

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 2,488.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд зөвлөмж өгч ажилласан.

#### **3.1 Төлбөрийн акт**

2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### **3.2 Албан шаардлага**

2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй болно.

#### **3.3 Зөвлөмж**

##### Илрүүлэлт 1:

Бүлгийн багш М.Батгэрэлд 2025 оны 1-р сард тушаал шийдвэргүйгээр хавсран ажилласны нэмэгдэл 1,042.0 мянган төгрөг олгосон байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ".

##### Илрүүлэлт 2:

Бат үндэс ХХК-д 2023 онд үүссэн өглөгийг тухайн байгууллагатай өр, авлагагүй гэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байхад өглөгийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 16.5.6 дахь заалт, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар шинэчлэгдсэн "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", Сангийн сайдын "Ангилал шинэчлэн батлах тухай" 2023 оны 211 дүгээр тушаал

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүлгийн багш М.Батгэрэлд 2025 оны 1-р сард тушаал шийдвэргүйгээр хавсран ажилласны нэмэгдэл 1,042.0 мянган төгрөг олгосон байна.	1	1,042.0					1	1,042.0		
Бат үндэс ХХК-д 2023 онд үүссэн өглөгийг тухайн байгууллагатай өр, авлагагүй гэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байхад өглөгийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.	1	1,446.0					1	1,446.0		
Нийт	2	2,488.0	-	-	-	-	2	2,488.0	-	-